

№ 10 / 2019 оны 11 сар

ЗЭРЛЭГ БАЙГАЛЬ ДАХЬ МЭДРЭМЖ

Байгаль хамгаалагч Л.Ойнбаяр тун үргэмтгий хулангийн сүрэгт ойртох туршилтад оролцохоор тусгайлан хийлгэсэн багаа өмсөж байна.

Та Говьд зэрлэг амьтан
болоод төрчихсөн бол
ях вэ?

Photo: © Cyril Ruoso.

Унаган тахь, түүний амьдрах орчныг хамгаалцгаая.

Тахийг хайрлан хамгаалдаг ЭРХЭМ АНД ТАНАА



уу, эсвэл үгүй юу?

Хүн төрөлхтөний ахуй соёл, техник технологийн хөгжил нь биднээс бусад төрөл зүйлийн амьд биетүүдийн оршин амьдрах хэлбэрийг хэрхэн өөрчилж байгааг ухааж ойлгоход хүнд болжээ. Тэдний тоо хэмжээ багасах үйл явц хорьдугаар зууны тавиад оноос хойш илүү хурдацтайгаар цөөрч ирсэн нь хүн ам хэт нэмэгдэж, байгаль дэлхийг улам бүр эзлэн түрэмгийлсээр байгаагийн шууд илрэл юм. Хүний үйл ажиллагаа манай экосистемийн нэгэн үндэс болсон шавьжны амьдралд хүртэл нөлөө үзүүлж буй нь аюулын том дохио болж байна.

Миний байгаль хамгаалах болсоны гол учир нь зөвхөн санаа зовсондоо биш л дээ. Би онгон дагшин байгаль дэлхий, зэрлэг амьтан, тэдгээрийн оршин байх зохилдлого нь маш үнэ цэнэтэй зүйл гэж боддог юм. Учир нь хүн төрөлхтөний бүтээн байгуулсан соёл, технологитой эн тэнцэхүйц дахин давтагдашгүй, юугаар ч орлууламгүй нандин зүйл энэ билээ. Бид өөрсдийнхөө төлөө, ирээдүйн төлөө тэднийг хайрлан хамгаалах хэрэгтэй. Өнөөдөр олон хүмүүс ийм бодолтой болсон нь сайн хэрэг. Бид устаж үгүй болохын ирмэг дээр ирээд байгаа амьтдыг өөрсдөөсөө хамгаалахад чиглэсэн дорвитой ажлуудыг хийх нь зүйтэй. Үүнд нэлээдгүй цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүчин чармайлт шаардагдах нь гарцаагүй.

Төв Азийн өргөн уудам тал нутагт тааваараа нүүдэллэн амьдардаг том хэмжээтэй хөхтөн амьтад нэн эмзэг зүйлүүдийн

ангилалд ордог юм. Өнөө үед хулан, тахь, зебра гэх мэтчилэн зэрлэг адууны ихэнх зүйлийн амьтад устах аюулд өртөөд байна.

Ийм учраас ОУТГ Монгол улсын засгийн газартай хамтран зэрлэг байгалиас бүрэн арчигдаад байсан тахийг Зүүнгарын говьд сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулсан билээ. Түүнчлэн энэхүү гайхалтай хөтөлбөрийн ачаар энэ жил газар нутаг нь хоёр дахин нэмэгдээд байгаа Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн шим мандлын нөөц газрыг хэдийгээр малчин айлууд ашиглаж байгаа ч бүрэн бүтнээр нь хадгалагдах боломжийг бүрдүүлсэн юм. Ингэснээр бид тэдний олон зууны турш үргэлжилсэн амьдралын хэв маягийг хадгалан авч үлдэхэд нь туслах юм. Ирээдүйд энэ газар нутаг нь тахь, хулан зэрэг бусад олон зүйлийн амьтад болон нүүдэлчин малчин айл өрхүүдийн аль альных нь өлгий нутаг болон үлдэх болно.

ОУТГ энэхүү ажилд хувь нэмэр оруулж байгаадаа үргэлж баяртай байдаг. Мэдээж хөрөнгө санхүүгийн асуудал хамгийн чухал нь байдаг. Бидэнд хандив өгч, тусалж дэмжиж байгаа байгууллага хувь хүмүүст маш их талархаж байна.

Др. Райнхард Шнидрих, Олон Улсын Тахь Группын ерөнхийлөгч

Энэ жил Монгол улсын их хурал Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн талбайн хэмжээг хоёр дахин өргөтгөж ойролцоогоор 18000 км.кв болгох шийдвэр гаргав. Энэхүү алсын хараатай шийдвэр нь сэргээн нутагшуулж буй тахийн ирээдүйн идээшил нутгийг тэлснээс гадна хулангийн сүргийн өвөлждөг цөм нутаг, аргаль, янгир, ирвэс зэрэг өндөр уулын амьтдын амьдрах орчныг хамруулжээ.

Photo: Rebekka Blumer



“Тоо толгой нь цөөрч устах аюулд ороод буй сүүлийн зэрлэг амьтдыг хүнээс, өөрсдөөсөө хамгаалахын тулд бид шийдвэрлэх арга хэмжээ авах хэрэгтэй байна.”

2019 оны онцлох үйл явдлууд

Өнгөрч буй онд бидний урдаа тавьсан гол зорилтуудын нэг нь Хамгаалалтын захиргааны төв байрны дулаалга, шинэчлэл, засварын ажил байлаа. Мөн өмнө нь 2016 онд төвийн ойролцоо гаргасан гүний худгийн усыг байгаль хамгаалагч болон зочин гийчдэд ашиглах боломжтой болгох нь чухал асуудал байлаа. Ийнхүү барилга байгууламжийн нөхцлийг сайжруулах, дэд бүтцийг шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэснээр өвлийг өнтэй давах боломжтой болсон төдийгүй байгаль хамгаалагчид, амралт зугаалгаар ирэх жуулчин гийчид, ажлаар ирдэг мэргэжилтнүүдийн тав тухтай байх нөхцлийг бүрдүүлж чадсан юм. Засвар шинэчлэлийн ажилд жилийн төсвийн 46% -ийг зарцуулсан тул “Том хөхтөн амьтдын тооллого- 2020” болон бусад судалгааны бэлтгэл зэрэг ажлуудыг ирэх жил хүртэл хойшлуулсан болно.

Бусад гол төсвүүд өмнөх жилүүдийн адилаар эргүүлийн автомашины түлш шатахуун, монгол дахь ажилчдын цалин хөлс болон судалгааны ажилд зарцуулагдав.

2019 оны ололт амжилтууд

Вонтобел ба Темперасио Сан, Жан-Пьер ба Соня Зигфрид Сан болон бусад олон хандивлагчдын өгөөмөр тусламж дэмжлэгээр бидний ажилд дараах амжилтууд гарлаа. Үүнд:

- Дархан цаазат газрын нийт хэмжээ нэмэгдлээ. (9'000km²аас 18'000km²)
- Барилга байгууламжийг сэргээн засварлаж, иж бүрэн тохижууллаа.
- Зэрлэг амьтан ба малын бэлчээр ашиглалтыг оновчтой болгох судалгааны ажлыг гүйцэтгэв.
- Зүүнгарын говьд сэргээн нутагшуулсан тахийн генийн шинжилгээ хийхэд зориулсан дээжийг цуглуулав.
- 8-12 насны хүүхдүүдэд зориулан тахь сэргээн нутагшуулах, хамгааллын сэдвээр танин мэдэхүйн ном гаргаж хэвлүүлэв.

Хамгаалалтын захиргааны байранд тавтай морилно уу!

Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хамгаалалтын захиргааны байрыг төв суурин газраас хол зайд Зүүнгарын уудам говь нутагт барьсан билээ. Байрны урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай байдаг ч энэ жилийн хувьд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

- 500 м-ийн зайд байрлах гүний худгаас цэвэр усны хоолойг хөлдөлтийн гүнээс доогуур татах, мөн өвөл ажиллах боломжтой бохирын септик систем суурилуулав.
- Барилгын хананд бүхэлд нь доторлогоо дулаалга хийж, цонх, хаалгуудыг шинээр сольж, нэмж зуух тавьсанаар өмнө нь зөвхөн тал нь халдаг байсан барилга өвлийн улиралд бүрэн халах боломжтой болов.
- Нөөц эрчим хүч хадгалдаг 10 кВт-ын хүчин чадалтай нарны зайн систем суурилуулав.
- Жан-Пьер ба Соня Зигфрид сангийн буцалтгүй тусламжаар Хонь ус, Тахь усны байгаль хамгаалагчдын байрны засварын ажлыг гүйцэтгэж; гадна талын хана, дээвэр, дотоод заслыг хийж хаалга, цонхнуудыг засварлав.

Хамгаалалтын захиргааны байранд хөрөнгө оруулснаар албан хаагчид болон зочдыг тав тухтай ажиллах, амрах нөхцлөөр хангав. Мөн УИХ-ын шийдвэрээр ТХГН-ийн талбайн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн нь ирээдүйд улам олон аялагчдыг хүлээн авах боломжтой болохыг харуулав. Эдгээр үйл ажиллагаанд хувь нэмэр оруулан тусалж дэмжсэн бүх



Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийг арчлан хамгаалахад зөвхөн машин тэрэг, шатахуун түлш, ажлын хувцас хэрэгслээс гадна чин сэтгэлээсээ, хүсэл сонирхолдоо хөтлөгдөн урам зоригтойгоор ажилладаг байгаль хамгаалагчид нэн чухал байдаг. Өмнө нь зөвхөн хэсэгчилсэн халаалттай байсан төв байр маань энэ жилээс бүхэлдээ халаалттай болсон. Ингээд төв байр маань өвөлдөө халаалтын асуудалгүй болсон учир бид удахгүй ОУТГ-тэй долоо хоног бүр скайпаар хийдэг конференц уулзалтууд дээрээ дулаан хувцас, малгай ороолттой суух шаардлагагүй болох нь байна. Хуучин цонхны хавтангуудыг орчин үеийн дулаалгатай цонхоор сольсон. Баянзүрх Ротари Клубын санхүүжилтээр барьсан шинэ худгийн байрыг 500м урт/3,2 м гүн дэхь хөлддөггүй усны хоолойгоор (-40° C/F хэмд ч хөлдөхгүй) төв байртай холбосон. Зурагт үзүүлсэн бохирын хоолой ч мөн адил хөлддөггүй материалаар хийгдсэн юм.



Монголын “Эрчим Электрик” ХХК-тай хамтран өмнөх системийг сольж 10 квт хүчин чадалтай нарны сэргээгдэх эрчим хүчний станцыг шинээр суурилуулав. Ингэснээр гүний худгийн усны шахуурга, төв байр, судлаачдын 3 гэр, ажилчдын хоёр гэрийг 220в-ын найдвартай эрчим хүчээр хангах болов. Энэхүү систем нь илүүдэл эрчим хүчээ өөрийн цэнэг хураагууртаа нөөцөлж, цэнэг нь дууссан үед шатахуунаар ажилладаг цахилгаан үүсгүүртэй холбогдон ажиллах боломжтой юм.

хандивлагчид, хамтран ажиллагсаддаа талархал илэрхийлье. Та бүхнийг хүрэлцэн ирж энэ бүгдийг өөрийн нүдээр үзэж сонирхохыг урьж байна. Говийн өвөл ямар байдгийг үзэж мэдрэхийг хүсч буй зочдод бидний үүд хаалга байнга нээлттэй. Харин малгай, ороолт дулаан хувцсаа базаагаарай.

Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны төв байрыг засч тохижуулснаар албан хаагчид болон зочид гийчдийн тав тух хангагдахын зэрэгцээ цаашдын ирээдүйд том хөрөнгө оруулалт боллоо.

Баянбүрдийн харуулын байрны засвар



Жан-Пьер ба Соня Зигфрид сангийн буцалтгүй тусламжаар Хонь ус, Тахь усны баянбүрд дахь байгаль хамгаалагчдын хээрийн ажлын байруудыг шинээр засаж, тохижууллаа. Манай байгаль хамгаалагчид энд буудаллах зочид гишчдийг дуртайяа хүлээн авна шүү!

ОУТГ нь экосистемийг хамгаалахаас гадна орон нутагт судалгаа шинжилгээ хийх, иргэдтэй мэдлэг мэдээлэл солилцохыг зорьж ажилладаг. Энэ жил ОУТГ нь Швейцарын Хөгжлийн Агентлагт хүсэлт гаргаж тэднээс тэтгэлэг авч тахийн тухай болон байгаль хамгаалах талаарх танин мэдэхүйн ач холбогдолтой 8-12 насны хүүхдүүдэд зориулан ном хэвлүүлээ. Уг номыг сургуулиуд болон номын сангуудад үнэгүй тараах юм. Маш цөөхөн хүн амтай газар нутагт онгон зэрлэг байгалийн нандин байдлыг бишрэн хайрлахдаа бид адил зарчимтай байх хэрэгтэй.

Энэхүү зурагт Швейцар улсын багш Ули Рутц орон нутагт чиглэсэн сурган хүмүүжүүлэх ажлын хүрээнд хүүхдүүдэд "укулеле" хөгжим тоглож сонирхуулж байгаа нь.

ОУТГ-ийн санхүүжилтээр тэдний нэрийн өмнөөс ажиллах болсон судлаач Сүхбаатарын Далайцэрэн тахийн хомоолноос дээж авч гормоны статус тодорхойлох генетикийн шинжилгээ хийлгүүлж байна. Нэг газартаа удаан тогтдоггүй, үргэмтгий амьтад учраас сорьц авахаар сонгосон тахинд ойртон очих нь ярвигтай ажил байв. ОУТГ-ийн судалгаа шинжилгээ хариуцсан захирал, доктор Петра Каченскигийн (Вена ба Норвегийн

Суралцсанаа хуваалцдаг



Photo: Далайцэрэн Сүхбаатар

ОУТГ-ийн санхүүжилтээр докторант Лена Михлер зэрлэг амьтан болон малын бэлчээрийг хэрхэн оновчтой хамтран ашиглах талаар судалгааны ажил хийж байгаа юм. Энэхүү судалгаагаар дархан цаазат газраар дамжин нүүдэллэж амьдардаг малчдын мал сүрэг бэлчээрийг хэт их ашиглахаас хэрхэн сэргийлэх талаар харуулах ба судалгааны үр дүн нь Хамгаалалтын захиргааны удирдлага болон малчдад аль алинд нь чухал мэдээлэл болох юм. Дархан цаазат газрын талбайг өргөтгөснөөр мал сүрэг нь ТХГН дотор зүй ёсоор бэлчээрлэх боломжтой болж буйд малчид сэтгэл хангалуун байна. Энэ нь түүний ашиглалтыг зохицуулахаас гадна шинээр ирж буй малчин өрхүүдийн хооронд өрсөлдөөн үүсэх болон уул уурхайн олборлолтоос сэргийлнэ. Дархан цаазат газрын хамтын удирдлагад оролцох гэсэн малчдын сонирхол яваандаа өсөн нэмэгдэх төлөвтэй байна. Лена Михлер судалгааны ажлынхаа хүрээнд үндэсний болон олон улсын судлаачдыг оролцуулсан семинар зохион байгуулж мал зэрлэг амьтад давхцан бэлчээрлэж буй янз бүрийн газарт жижиг хэмжээтэй судалгааны талбай сонгож тэндхийн даацын талаар мэдээлэл өгсөн юм.



хамтарсан Байгаль Судлалын Институтийн дэргэдэх Мал эмнэлгийн эм зүйн Их Сургууль, Трондейм) удирдсан үнэлгээний ажлын үр дүн нь тахийн генетикийн олон янз байдлын талаарх бидний ойлголтыг улам өргөжүүлэх болно. Сэргээн нутагшуулсан манай тахиуд нь амьтны хүрээлэнгүүдэд амьд үлдсэн сүүлчийн 13 тахийн үр удам юм. Энэ төрөл зүйл нь 20-р зууны 60-д онд зэрлэг байгальд бүрмөсөн устаж үгүй болсон байсан билээ.



Экосистемийг хамгаалахаас гадны орон нутгийн иргэдийн дунд сургалт судалгаа явуулж, тэдэнтэй мэдлэг мэдээлэл солилцох нь ОУТГ-ийн гол ажлуудын нэг юм.


Photo: © Cyril Ruoso.

Зэрлэг байгалиас суралцах нь: Тахь нутагшуулах үйл ажиллагааны мэдээлэл

Монгол улс ОУТГ-тэй хамтран Говийн их дархан цаазат газар "Б" хэсэгт тахийг сэргээн нутагшуулж эхэлснээс хойш 27 жил өнгөрчээ. Тэр үед энэхүү төслийн ирээдүй тун бүрхэг харагдаж байлаа. Учир нь бараг л устаж үгүй болсон гэж хэлж болохоор энэхүү амьтны хэзээ ч зэрлэг байгальд амьдарч үзээгүй ердөө 13 толгой бодгалийн үр төлүүд л дэлхий дээр үлдсэн байсан. Энэ ажлыг амжилттай хэрэгжүүлснээр устаж үгүй болохын ирмэгт байгаа амьтдыг сэргээн, байгальд нь дахин нутагшуулж болдог юм байна гэдгийг баталж өглөө.

Монголд тахь нутагшуулах үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаа нь орон нутгийн иргэд анхнаас нь дэмжиж, халуун дотноор хүлээн авсантай холбоотой. Мэдээж хэрэг бүх зүйл амархан байгаагүй. Амьтдыг гаршуулсанаар тэдний хүрээлэн буй орчинд хариу үйлдэл үзүүлэх байгалийн зөн совин нь бүхэлдээ алга болох буюу эсвэл бүдгэрдэг. Генетикийн үүднээс ийм програмчлагдсан чадвар нь суларсан амьтныг буцааж зэрлэгшүүлнэ гэдэг нь найдварыг тун бага болгож байгаа хэрэг. Үнэхээр ч Монголд ирсэн анхны тахиуд өвс тэжээлээ олж идэхээс эхлүүлээд говийн байгалийн орчинд дасах хүртэл нилээд хугацаа шаардагдсан юм. Удаан хугацаанд үргэлжилсэн зарим асуудлыг шийдэхэд туршлага дутагдсаар байв. Популяцын өсөлт хэдий чинээ удаан байх тусам тэдний сүргийн бүтэц, зан төрх, идэш тэжээлийн төлөөх өрсөлдөөн улам бүр ширүүсдэг бөгөөд энэ нь орон зайн ашиглалтын динамикийг нэмэгдүүлдэг. Эхний жилүүдэд тэд анх хашаанаас гарсан газраасаа бараг холддоггүй байсан боловч 2015 оны намар гэхэд хоёр ч сүрэг анх удаа зүүн зүгт байх Хонь уснаас баруун зүгт 70 км зайд орших Тахь ус руу өөрсдөө шилжилт хөдөлгөөн хийж чадсан юм. Үүнээс хойш дөрвөн жилийн дараа гэхэд нийт тахийн 9 орчим хувь нь (Могой, Хаан азаргатай сүргүүд) дээрх 2 баянбүрдүүдийн хооронд тогтмол шилжилт хөдөлгөөн хийх болж ирж очих зам, шинэ нөөц бэлчээрийг мэддэг болсон байна. Хоёр тахь бүр дархан цаазат газраас гараад явчихсан байсан. Эгч дүү тахиуд болох Елушка/Elushka шүдлэн байдас, Альфа/Alpha / эр даага 2019 оны 6-р сарын сүүлээр байршил нутгаа бүрэн сольж Зүүнгарын говиос гарч Алтайн өвөр говийн харъяа Алагнуурын говьруу орсон юм. Тэдний шилжилт хөдөлгөөн бүрийг байгаль хамгаалагчид маань аль болох алдалгүй тэмдэглэж авахыг хичээсээр байна.

Development of the takhi population
Great Gobi B, 1992 - July 2019



Долдугаар сарын сүүлээр нийт тахийн тоо 278 толгойд хүрч дөрөв дэхь удаагаа дээд амжилт тогтоов. 2009-2010 оны өвөл болсон зудаас хойш жил бүр тахийн тоо толгойн өсөлт 20 орчим хувьтай байв. Энэ эрчээр явбал дараагийн 3 жилд тоо толгой нь хоёр дахин нэмэгдэж, 2025 он гэхэд нэг мянга хүрэх төлөвтэй байна. Ингэж үргэлжлэн өсөхийг байгалийн гамшиг зуд, халдварт өвчин, эрлийзжилт зэрэг хүчин зүйлүүд хязгаарлаж болно.

Эмгэнэл

Эрдэмтэн Бадамжавын Лхагвасүрэн (1959-2019)


Энэ оны 8-р сарын 1-ний өдөр ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторийн



эрдэм шинжилгээний тэргүүн ажилтан, дэд профессор, доктор Бадамжавын Лхагвасүрэн зуурдаар таалал төгслөө. Тэрээр Нүүдэллэдэг зүйлүүдийн олон улсын конвенц (CMS) болон Олон улсын тахь группын (ITG) судалгааны зөвлөлийн гишүүн байсан юм. Монголын хөхтөн амьтан судлалын томоохон мэргэжилтнүүдийн нэг тэрбээр цагаан зээр, бөхөн, хулан, тахь зэрэг амьтдын судалгааг хийж, эдгээр зүйлүүдийнхээ хамгаалалтанд биечлэн оролцож явжээ. Лхагвасүрэн нь Монгол улсад хашаа, хаалт зэрэг зам, дэд бүтцээс болж хөхтөн амьтдын шилжилт хөдөлгөөнд саад

бэрхшээл учирч байгаа асуудлыг анх гаргаж тавьсан анхны монгол эрдэмтэн юм. Тэрээр зэрлэг амьтдыг төмөр замаар нэвтрэх боломжтой болгох ажлыг хэрэгжүүлэхийг зорьж байсан билээ. Тиймдээ ч түүний санаачлагаар бүтэн 3 жилийн турш үргэлжилсэн хэлэлцээрийн дагуу Швейцар улсын санхүүгийн дэмжлэгтэйгээр тодорхой газруудад төмөр замын хаалт, хашааг зэрлэг амьтад нэвтрэх боломжтой болгож солиулж зарим хэсгийг нь бүрмөсөн буулгаж, ингэснээр хулангийн сүрэг говь, тал нутгаар дамжин нүүдэллэх боломжтой болж эхэлсэн билээ. Энэхүү үнэлж баршгүй амжилтынх нь төлөө бид түүнд гүн хүндэтгэл, талархал илэрхийлэх ёстой юм. ОУТГ-ийн зүгээс түүний гэр бүл, үр хүүхэд, төрөл төрсөгсөд нь гүн эмгэнэл илэрхийлж байна. Бид түүний гэгээн дурсгалыг үргэлж хүндэтгэх болно. Түүний ууган хүү аавынхаа ажлыг үргэлжлүүлж Монголын байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах үйлсэд хүчин зүтгэхээ мэдэгдсэнийг энд дурьдахад таатай байна.

Takhi population structure
Great Gobi B SPA, 2019



2015 оны байдлаар дархан цаазат газрын нийт тахийн сүргийн гуравны хоёр нь гүү байв. Харин азарганы тоо толгой өссөөр өнөөгийн байдлаар нийт сүргийн 42 хувийг азарга эзэлж байгаа нь цаашид хүйсийн харьцааг тэнцвэртэй болохыг илтгэнэ. Ингэснээр сүргийн тоо өсөн нэмэгдэх боломжтой болж улмаар хулан, тахь, малын хооронд бэлчээрийн төлөөх өрсөлдөөн ч нэмэгдэнэ.



Тахь усны баянбүрдийн цорын ганц азарган үрээ Цуут (зүүн талынх нь) залуу байдасны анхаарлыг татаж чадлаа! Энэ баянбүрдийн орчимд нялх унаганы гарз хохирол ихтэй тул чононоос хамгаалсан хашаанд түр хугацаагаар идээшин нутаглаж байгаа сүргийн тэргүүн (баруун талынх нь) Цуутын нүүрэмгий түрэмгий авирыг огт тоосонгүй. Гэсэн хэдий ч залуу тахь ижлээ олох нь эргэлзээгүй.

Photo © Cyril Rouso


Сүргийн тоо толгойн өөрчлөлт: “Цуут” нэртэй азарга ижлээ олжээ

Өнгөрсөн жил залуу үрээнүүд сүргээсээ хөөгдөх нь элбэг байснаас үүдэж үржлийн сүргийн тоо толгойд нэлээд өөрчлөлт гарсан. Хонь усны популяцид 35, Тахь усны популяцид 3 тоо толгой бүхий азарга үрээний сүрэг байна. Харин 2015 оноос шинээр 15 азарга өөрийн үржлийн сүргийг үүсгэжээ. Тэдний нэг нь манай уншигчдын хэдийнээ танил болсон, хувь заяаны эргүүлэгт төөрч будилан явсаар ижил сүргээ олсон 4 настай “Цуут” хэмээх өнчин тахь билээ.


Яваандаа хүйсийн харьцаа улам бүр тэнцвэртэй болсоноор азарга үрээнүүд өөрсдийн сүргийг үүсгэх явдал элбэгшиж улмаар үржлийн сүргийн тоо нэмэгдсээр байх болно.

Дээрх графикт 2015-аас 2019 оны хооронд Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэг дэхь тахийн сүргийн тоо толгой хэрхэн өөрчлөгдсөнийг харууллаа. Дөрвөн жилийн дотор нийт тахийн тоо толгой бараг хоёр дахин өсч, нэг сүрэг дунджаар тогтмол 9.5-11 тахьтай болоод байна. 2015 оны байдаар 10 азарга үржлийн сүрэгтэй байсан бол одоогийн байдлаар 8 азарга нь үржлийн сүргээ тэргүүлсээр байна. Номхон азарганы сүрэг 2015 онд хамгийн том сүрэг нь байсан бол энэ жил сүүлээсээ хоёрдугаар байранд орж, харин залуу азарга Цуут ганц гүүтэй шинэ сүрэг үүсгэжээ. 2015 онд хамгийн жижигт тооцогдож байсан Могой азарганы сүрэг шинээр 14 зэрлэг тахьтай болж хоёрдугаар байранд орсон байна.

Harems and Harem Sizes 2015



Harems and Harem Sizes 2019



Дөрөвхөн жилийн дотор сүргийн тоо хоёр дахин нэмэгдсэн.

Унаган зүйлүүдийн тухай хөрөг зураг булан

Өөхөн-сүүлт атигдаахай (Thick-tailed pygmy jerboa)

Тэд бол өчүүхэн жижиг турьхан биетэй, том толгой, хурц хар нүдтэй, имжнийх шиг сүүлтэй мэргэгчид юм. Биеийн жин нь ердөө 7-24 гр бөгөөд дэлхий дээрх хамгийн жижиг хөхтөн амьтдын тоонд ордог. Тэд говийн хатуу ширүүн уур амьсгал, орчин нөхцөлд хэрхэн амьдардаг вэ?

Өөхөн-сүүлт атигдаахай нь (*Salpingotus crassicauda* Vinogradov, 1924) алаг дааганы төрлийн нэгэн мэргэгч амьтан юм. Заг, харгана мэтийн ургамлыг мэргж хооллохын зэрэгцээ 15-30 хувь хүртэл уураг агуулсан илчлэг өндөртэй хүнс болох царцаа голдуу шавьж хорхойгоор хооллодог. Ингэснээр хангалттай хэмжээний илчлэг авч, тамир тэнхээтэй болсон алаг даага нь илүүдэл өөхөө сүүлнийхээ унги хэсгээс эхлэн хуримтлуулж өвлийг өнтэй давах боломжтой болдог ба 9 дүгээр сараас эхлэн 6-8 сарын турш ичээндээ ордог. Энэ үед тэдний биеийн хэм нь 2-3°C болж буурах бөгөөд нийт жингийнхээ бараг талаас илүү хувийг нь алддаг.

Өөхөн-сүүлт атигдаахайнууд зуны улиралд бараг хагас хоног шахам үзэгддэггүй нь говийн халуунаас зугтдагтай нь холбоотой юм. Өдрийн цагт газар доор 10-30 см гүнд ухсан нүхэндээ хоргодох ба шөнийн цагт хаа нэг нүхнээсээ гарч ирнэ. Нүх нь олон талаасаа орох боломжтой байдаг. Тэд нүхнийхээ амсрыг элсээр дардаг нь гаднаасаа харагдахгүйн дээр дотроо сэрүүн байдаг. Тэд ганц нэгээрээ амьдардаг ба бүл үүсгэдэггүй.

Эргэн тойрондоо олон махчин дайсантай тул ойр ойрхон зугтах хэрэгцээ гардаг жижиг мэргэгчийн хувьд нарийн ширхэгтэй, сул элстэй газар амьдрах нь эрсдэлтэй байдаг. Гэхдээ энэхүү жижигхэн амьтан энэ нөхцөлд маш сайн нуугдаж чаддаг. Ар талын том хоёр хөл дээрээ дүүжигнэн үсэрч явах бөгөөд их бие нь урт үсээр бүрхэгдсэн байна. Ингэж үсрэхдээ 0.5 га хэмжээтэй газар нутгаа 2 м/с хурдтай туулдаг байна. Түүгээр ч зогсохгүй давхиут дундаа огцом чиглэлээ өөрчилдөг тул араас нь хөөж байгаа амьтдад



Photo © Klaus Rudloff, Berlin

хүндрэл учруулдаг. Бусад алаг даагануудаас ялгаатай нь тэд хоргодох газраа өөрсдөө ухдаггүй. Шаардлагатай үед тэд заг харгана дор нуугдчихдаг.

Хавар үржлийн үед эрэгчин атигдаахайнуудын нутаглах газрын хэмжээ бараг 3 дахин ихсэж 2 га орчим болдог. Тэд газар нутгаа өрсөлдөгчөөсөө хатуу хамгаалдаг. Эмэгчин нь жилд хоёр удаа 2-4 зулзага гаргана. Тэд хээлтсэнээс хойш 3-4 долоо хоногийн дараа төрж 9-11 сарын дараа нас бие гүйцдэг. Анх удаа нүхнээсээ гарахдаа зулзаганууд нь эхийнхээ араас цуварч гарах ба эргэж ирэхдээ мөн ижил дарааллаар цуварч ордог байна. Хэд хоногийн дараа энэ зан төрхөө орхидог.

Атигдаахайн амьдрал маш их аюулын дунд байдаг. Тэд могой, шар шувуу, гүрвэл зэрэг дунд зэргийн хэмжээтэй махчин амьтдын хамгийн дуртай хоол нь юм. Одоогоор мэдэгдээд байгаа 35 төрөл зүйл Хойд Америк, Араб, Бага Ази, төв болон зүүн Азид амьдардаг. Тэд 4 дэд бүлэгт хуваагддаг бөгөөд тэдний дотор алаг дааганы 7 зүйл байна. Ихэнх алаг дааганууд нам жим, ганцаараа амьдардаг. Зарим төрөл зүйл нь богино зайд гүйдэг (30-50 км/ц, шөнөдөө 5-10 км/ц хурдаар туулна). Сибирь алаг даага өндөр үсэрч хүр эрвээхэйнүүдийг барьж иддэг. Алаг дааганууд экосистемд чухал үүрэг гүйцэтгэдэг – үүний дотор тахлын вирус гэх мэт өвчин үүсгэгч бичил биетнийг биедээ агуулахыг оруулж үздэг.

Зарим төрөл зүйл нь маш өргөн тархаж бараг хортой зүйлийн хэмжээнд тооцогддог. Харин зарим нь IUCN-ийн Улаан дансанд орж дэлхий даяар цөөхөн хэдэн газарт тархаж, ховордсон байдаг. Амьдрах орчны хомсдол, шууд устгах, ган гачиг, зам тээвэр зэрэг янз бүрийн хүчин зүйлүүд тэдэнд нөлөөлж байна. Үүнд бид санаа зовохгүй байх аргагүй юм. Том хэмжээтэй ургамал, амьтны аймаг, төрөл зүйлүүд бидний анхаарлыг илүү татдаг учраас экосистемд тэд л хамгийн чухал үүрэгтэй гэж бид боддог. Харин ч хамгийн жижиг амьтдын экосистемд үзүүлэх нөлөө нь хамгийн их байдаг юм шүү.



Photo © Klaus Rudloff, Berlin

¹ Michaux JR & Shenbrot GI in Handbook of the Mammals of the World (2017): Vol. 7; 61-84

² Photo source: kdrudloff(at)web.de, <http://www.biolib.cz>

Таны тусламж бидэнд хэрэгтэй.

Байгаль хамгаалах ажил нь тийм ч сүр дуулиантай байдаггүй. Ялангуяа дадал болсон ар талын ажлыг амжилттай төсөл болгох нь амаргүй ажил юм.

Тиймээс таны өгсөн хандив тусламжаар хичнээн өөрчлөлт хийж болохыг та эндээс харж болно. Өгч буй хандив бүр бидэнд үнэ цэнэтэй, бид хүлээн авахдаа үргэлж таатай байна.



CHF/USD 20.-

50.000 төг

Байгаль хамгаалагчийн нэг өдрийн томилолт, ажлын хэрэгсэл.



CHF/USD 60.-

160.000 төг

УИХ-ын тогтоолоор 2019 онд ДЦГ-ын өргөтгөлт батлагдсантай холбогдуулж хүмүүсийг мэдээллээр хангах.



CHF/USD 100.-

270.000 төг

Байгаль хамгаалагчдын машин, мотоциклын засвар, үйлчилгээ.



CHF/USD 150.-

400.000 төг

Дархан цаазат газрын уст цэгийн менежментийн судалгааг санхүүжүүлэхэд тусалж чадна.



CHF/USD 250.-

650.000 төг

Байгаль хамгаалагчдын эргүүл, хяналт шалгалтын нэг сарын зардал.



CHF/USD 500.-

1.300.000 төг

Байгаль хамгаалагчдад зориулсан “Том хөхтөн амьтдын цэгэн тооллого 2020” –ын сургалтын зардлыг санхүүжүүлэхэд тусалж чадна.

ОУТГ-ийн гишүүд нь сайн дураар ажилладаг. Бүх хандив тусламж тахийг хамгаалах үйлст зарцуулагдах болно.

“Бидэнтэй нэгдэж Тахийн нөхөд болох боломж Танд байна!”

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **130,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **50,000 төгрөг**

Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь товчоо

499114883 ам. долл.

499248691 төгрөг

Эрхлэн гаргасан

Олон Улсын Тахь Групп
нийгэмлэг Тахийн нөхөд

Вилдниспарк Цюрих сан
Алтэ Зийлталштрассэ 38

CH-8135 Зийлвалд

Швейцар улс

www.savethewildhorse.org

info@savethewildhorse.org

itg.ulaanbaatar@gmail.com

itg.ub.marketing@gmail.com



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP



Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC
(Ойн Удирдах Зөвлөл) / ЕХ Эко шошгоны цаас

